



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 01 өдөр

Дугаар А/121


Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай


Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Төсөв батлах тухай" 2019 оны 23/15 дугаар тогтоол, Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/385 дугаар захирамж, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5, 3.1.21 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Засаг даргын 2019 оны "Эрх шилжүүлэх тухай" А/385 дугаар захирамжийн 2 дугаар хавсралтаар батлагдсан Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 2019 онд санхүүжүүлэх нийтийн зориулалттай орон сууцны барилгын цахилгаан шатны засварын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор байгуулсугай.

2. Дээрх ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохион байгуулж, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, зөвлөмжийг Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар /Б.Мөнхбат/-т хүргүүлэхийг Үнэлгээний хороо /Т.Хэрлэн/-нд үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн
2019 оны 05 сарын 01
өдрийн 11:31 тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	Т.Хэрлэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн дарга
Гишүүд	Р.Даваасүрэн	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Т.Оюунтөгс	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа санхүүгийн хэлтсийн ахлах мэргэжилтэн
	Н.Энхбат	Чингэлтэй дүүргийн 2 дугаар хорооны иргэн /зөвшилцсөнөөр/
Нарийн бичгийн дарга	Б.Отгонбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн